

ХӨЛӨНӨҮЙР СУМЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН УЛСЫН БАЙЦАГЧ А.ГАНЦЭЦЭГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (Биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
НЭГ. "НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО ТӨӨЛӨРҮҮЛЭХ, ХАМРАГДАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ ОЛГОХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.1	Ажил даатгуулагчдын хамралтыг нэмэгдүүлэн орлогын төлөвлөгөөг биелүүлэх.	2024 онд ажил олгогч байгууллага	Орлогын төлөвлөгөөт жилд биелүүлэн ажиллана.	1 ажил олгогч, даатгуулагчийг хамруулах	Шинээр 1 ажил олгогч хамруулсан. Бүлэг Арвижих ундарга ХХК-ийг шинээр нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэрхээр бүртгэсэн.	2025.01.01 2025.06.30	100%
1.2	Ажил даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог системд хянаж баталгаажуулах.	2024 оны 16 байгууллагын тайлан	Нийгмийн даатгалын тайланг хугацаанд нь бүрэн хүлээн авна.	17 ААНБ-ын тайлан	17 ААНБ-ын нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог нэгдсэн системд хуулийн хугацаанд оны эхнээс хүлээн авч баталгаажуулж байна. 2-р сараас Төрийн банк суманд НДШ-ийн тайлан өгдөг байсан боловч аймгийн төвдөө нэгдсэн тайлан өгдөг болсон.	2025.01.01 2025.06.30	100%

1.3	Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, авлагыг бууруулах.	100%	Шинээр шимтгэлийн авлага үүсгэхгүй ажиглана	100% өргүй байна	5 сарын байдлаар өмнөх сарын өртэй байсан төсөвт байгууллагууд бүгд өглөг, авлага үүсгээгүй. Хоёр аж ахуй нэгж дээр 703320 төгрөгийн авлага үүссэн. 2025 оныг даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бууруулах жил болгон зарласан тул энэ хагас жилийн байдлаар бүх ажил олгогчдыг шимтгэлийн өглөг, авлага үүсгэхгүй байна.	2025.01.01 2025.06.30	100%
1.4	Ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд болон малчдыг сайн дурын даатгалд хамруулан гэрээ байгуулж, шимтгэлийг төлүүлэх.	142	Сайн дурын даатгалын хамралт нэмэгдсэн байна.	6	Сайн дурын даатгалд шинээр малчнаар 12 даатгуулагч, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэнээр 3 даатгуулагч НДШ төлж байна. Нийтдээ 146 даатгуулагч хамрагдаж гэрээгээ байгуулсан. Үүнээс Энгийн сайн дурын даатгалд 26 даатгуулагч, малчдын сайн дурын даатгалд 120 даатгуулагч хамрагдаад байна.	2025.01.01 2025.06.30	100%
1.5	0-3 насны хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийг сайн дурын даатгалд хамруулан гэрээ байгуулж, шимтгэлийг төлүүлэх.	33	Бүрэн хамрагдсан байна	5	Сайн дурын даатгалд шинээр 0-3 насны хүүхэдтэй эхээр 4 даатгуулагч шимтгэл төлж хамрагдаж байна. Нийтдээ 28 даатгуулагч гэрээгээ байгуулан шимтгэл төлж байгаагаас 0-3 насны хүүхдээ асарч буй 25 эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг/эх-ийн сайн дурын шимтгэл төлөгч 3 даатгуулагч хамрагдаад НДШ төлж байна.	2025.01.01 2025.06.30	85%

1.6	Даатгуулагчдаас тэтгэвэр, тэтгэмжийн баримтыг хүлээн авч мэдээллийг нэгдсэн системд бүртгэн тогтоолт, олголтыг хугацаанд нь гүйцэтгэх.	25 тэтгэвэр тогтоосон	Тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь олгоно.	Тэтгэвэр тогтоологдох баримтыг бүрэн хүлээн авч, тогтоож, хянуулна.	Даатгуулагчдаас тэтгэврийн материал хүлээн авч нийт 9 тэтгэвэр шинээр тогтоон, хугацаандаа тэтгэвэр олгогдоод явж байна. Үүнд Өндөр насны тэтгэвэр 6, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 2, тэжээлчээ алдсаны тэтгэвэр 1 шинээр тогтоогдсон.	2025.01.01 2025.06.30	100%
1.7	Нийгмийн даатгалын үйлчилгээтэй холбоотой мэдээ судалгаа, тайлан гаргах.	Сайн дурын даатгалд хамрагдалтын тайлан, Сургалт сурталчилгааны тайлан	Чанартай гаргаж хугацаанд нь хүргүүлнэ.	Сайн дурын даатгалд хамрагдалтын тайлан, Сургалт сурталчилгааны тайлан, иргэдийн судалгаа мэдээ-2	Нийгмийн даатгалын үйлчилгээтэй холбоотой мэдээ тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Тухайлбал: 0-3 насны эхийн болон ажил олгогчийн авлагын мэдээ, 18-аас дээш насны иргэдийн судалгааг 1 сард, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тэтгэврийн хувийн хэргийн тооллого мэдээг 3 сард, Сургалт сурталчилгаа хийсэн тоон мэдээг 4 сард, Гадаад улсад түр болон удаан хугацаагаар амьдарч байгаа ХЧА-ны тэтгэвэр авагч иргэдийн судалгаа, Төлөвлөгөөний биелэлтийг 6 сард гарган хүргүүлсэн.	2025.01.01 2025.06.30	100%
1.8	Улсын байцаагчийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавин ажиглах.	Улсын байцаагчийн 1 акт тавьсан; Индш тэлүүлэх тухай/	Бүрэн барагдуулж ажиглана.	Улсын байцаагчийн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажил	Зөрчил гараагүй	2025.01.01 2025.06.30	100%
ХОЁР. "ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
2.1				150 хүнд	Ажлын байран дээр зөвлөгөө авахаар ирсэн иргэдэд нийгмийн даатгалын цахим үйлчилгээний мэдээллээр хангах, туслах, үйлчилгээг үзүүлж байна. Иргэд	2025.01.01 2025.06.30	100%

Ажил даатгуулагчдад Нийгмийн даатгалын багц хууль болон бусад хууль тогтоомжийн талаар сурталчилгаа хийж зөвлөгөө өгөх, цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх.	2024 онд мэдээлэл сурталчилгаа зохион байгуулахад оролцсон иргэдийн тоо-255	Ажил олгогч, даатгуулагчдын мэдлэг дээшилнэ.	цахим үйлчилгээнд бэлтгэгдээгүй, хэрэглэж хэвшээгүй учраас мэдэхгүй байгаа даатгуулагч иргэдэд өөрийнх нь эрхээр орж хамтран ажиллах, мэдээллийг нь гарган авч өгч байна. Дараа нь та бүхэн дахин энэ үйлчилгээг авах бол portal.ndaaval.mn, e-mongolia.mn хөтчөөс аваарай гэдэг зөвлөгөө өгч ажилласан. Цэцэрлэг болон ЭМТ-ийн ажилтан алба хаагч нарт нийгмийн даатгалын багц хуулийн талаар мэдээлэл өгсөн. Баян-Өлзийт, Батхаан, Баян-Уул багийн Засаг дарга нартай хамтран 55-аас дээш насны эрэгтэй, 50-аас дээш насны эмэгтэйчүүдийн судалгааг гарган өндөр насны тэтгэвэрийн насны эрх үүссэн иргэдтэй холбогдон зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, малдчийг сайн дурын даатгалд хамруулах, малчны тэтгэврийн тухай зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг 2 сард малчдын битүүлэг арга хэмжээнд-150 иргэн, 5 сард Улаанбаатар хотноо арга хэмжээ-55 иргэн, Баян-Өлзийт, Батхаан, Баян-Уул багийн ИНХ-д 112 иргэнд мэдээлэл тавьж танилцуулсан. Нийт 262 иргэнд мэдээлэл, тараах материал хүргэн ажилласан.		
--	---	--	--	--	--

2.2	Ажил нийгмийн олгогчдын даатгалын шимтгэлийн тайланг тоон гарын үсгээр баталгаажуулан хүлээн авах.	16 ААНБ-ын тайлан хүлээн авдаг	Тоо гарын үсгийн хэрэглээг бүрэн нэвтрүүлнэ	3	Аж ахуй нэгж байгууллагын удирдлагууд portal.ndaaval.mn вэбээр ндш-ийн тайлангаа өөрсдийн эрхээрээ гаргаж байна. Монгасс тоон гарын үсэг ашиглаж байсан 3 байгууллага байсан. Тэд шинэ системд нэвтэрснээс хойш тоон гарын үсгээр тайлан илгээхгүй дан систем ашиглан тайлан илгээж байна.	2025.01.01 2025.06.30	100%
2.3	Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг иргэд даатгуулагчдад https://portal.ndaaval.mn/ сурталчилан, ашиглаж мэдээлэл түгээх	Сар бүр 1 удаа	Даатгуулагчид цахим програм ашиглаж сурсан байна.	6	Цахим үйлчилгээг хөгжүүлэх portal.ndaaval.mn, e-mongolia.mn вэб сайтуудын үйлчилгээнүүдийг танилцуулж, үйлчилгээ мэдээлэл танилцуулж байна. Сайн дурын даатгалын шимтгэлийг цахимгаар төлөх боломжуудыг сурталчилах хамралтыг сайжруулах зорилгоор сумын фэйсбүүк пейж хуудсаар дамжуулан мэдээлэл өгч тухай бүр пост оруулж байсан. Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар авах боломжийг хангах зорилгоор цахимаар Хөлөнбуйр сумын нийгмийн даатгал фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд НДГТ болон Дорнод аймгийн нийгмийн даатгалын газрын фэйсбүүк хуудсын 95 мэдээлэл постлосон мэдээг шийр хийн түгээн хүргэж үйлчилсэн.	2025.01.01 2025.06.30	100%
2.4	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт, өөрчлөлт, үйлчилгээний талаар сумын удирдлага, ЗДТГ-ын ажилтнуудаад мэдээлэл өгөх	2024 онд төрийн байгууллага, албан хаагчдад сургалт мэдээлэл өгсөн тоо.	Нэгдсэн мэдээлэлтэй болж, ажил төрлийн үйлдвэр сайжирна..	2	Сумын удирдлага, төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, ЗДТГ-ын ажилтнууд оролцож долоо хоног бүрийн даваа гаригт 08:30 цагт шуурхай хурал хийдэг. Уг хурал мэдээллийн цагт нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт,	2025.01.01 2025.06.30	100%

		Төсөвт байгууллагын нягтлангуудад 1 удаа сургалт хийсэн. Тухай бүр мэдээлэл өгч ажилласан.			өөрчлөлтийн талаар 7 удаа танилцуулж мэдээлэл өгсөн байна.		
2.5	Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулахад бүтээлч шинэ санаачлага гарган ажиллах.	2024 оны хэрэгжүүлсэн ажил, тоо байхгүй	Үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн байна.	2	Долоо хоног бүрийн баасан гаригт сумдын байцаагчдыг хамруулан цахимгаар хийдэг байгууллагын хуралд Хөлөнбуйр сумынхаа ажил хөдөлмөр эрхэлдэг болон ажилгүй иргэдийн судалгаа гаргаж 5 минутын РРТ хийж танилцуулсан. Дорнод аймгийн НДГ-ын залуучуудын зөвлөлөөс зарласан Нийгмийн даатгалын РР төлөвлөгөө, лого, уриа үг зохиох, уралдаан зарласан. Үүнд Нийгмийн даатгалын логоны 2 загвар гаргаж, 4 уриа үг, РР төлөвлөгөө зохион идэвхитэй оролцсон.	2025.01.01 2025.06.30	100%
2.6	Ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлтийг хүлээн авч, үндэслэлийг хянан цахим системд бүртгэн, тэтгэмжийн байцаагчид шилжүүлэх	10 ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт ирсэн	Хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэртэй	Хүсэлт гаргасан иргэдийн баримтын бүрдлийг хянан, тэтгэмжийн байцаагчид шилжүүлэх	Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт авахаар 6 даатгуулагч материал бүрдүүлж өгсөн. Үүнээс 3 даатгуулагч эрх үүсэн ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж тогтоож, хуваарийн дагуу олгосон. Харин 3 даатгуулагч-д ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүсээгүй байна.	2025.01.01 2025.06.30	100%

**ТУРАВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

3.1	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, шаардлагатай бусад тоо баримт, удирдлагаас хүргүүлсэн мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	2024 оны хагас болон бүтэн жилийн үнэлгээ Хагас жилээр ажигдаа ороогүй байсан тул үнэлүүлээгүй. Бүтэн жилийн үнэлгээ-90%	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хагас жилээр тайлагнах	Төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж ЗДТГ-ын даргаараа баталгаажуулж, аймгийн төврүү хүргүүлсэн. Төлөвлөгөөний биелэлтээ хагас жилээр бичиж, хуулийн хугацаанд хүргүүлсэн. Нийгмийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой Тушаал, шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.	2025.01.01 2025.06.30	100%
3.2	Даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, албан бичигт хариу төлөвлөх, өгөх.	2024 оны нийт ирүүлсэн гомдол, түүнээс хугацаанд хаасан гомдлын тоо-байхгүй	Хуулийн хугацаанд өгч хариу шийдвэрлэсэн байна.	Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг холбогдох албан тушаалтанд уламжлах, хариу хугацаанд нь шийдвэрлэж ажиглана.	1991 оноос хойшх Нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан тодорхойлолт авах хүсэлтийг иргэдийг олон дахин явуулхгүйгээр дотооддоо эйблв системээр дамжуулан цахимаар солилцон авч лавлагааг олгон ажиглож байна. Дорнод аймгийн нийгмийн даатгалын газрын архийн баримтаас 3 хүний лавлагаа гаргуулан эйблв системээр хүлээн авсан. Тэтгэвэр авагчдын банк солиулах 10 хүсэлт ирснийг шийдвэрлэсэн.	2025.01.01 2025.06.30	100%

3.3	Тайлант ажигл нийгмийн шимтэгийн зогсоогдсон хэрэг болон баримтыг хадгаламжийн үүсгэн архивт хүлээлгэн өгөх.	2024 онд 2	Архив, албан хэрэг хөтөлтийн зааврын дагуу ажиглана.	Нийгмийн даатгалын тайлан зогсоогдсон хувийн хэрэг болон бусад бичиг баримтыг архивт цаг хугацаанд нь хүлээлгэн өгнө.	Өнгөрсөн оны төсөвт болон аж ахуйн нэрж байгууллагын шимтгэл төлөлтийн тайлан-2 меморал, тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаад зогсоогдсон хувийн хэргийн баримтуудыг үдэн бүртгэлд оруулан энэ оны 1 улиралд багтаан архивт хүлээлгэн өгсөн.	2025.01.01 2025.06.30	100%
-----	--	------------	--	---	---	--------------------------	------

ДӨРӨВ. НЭМЭЛТ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

4.1	Удирдлагаас үүрэг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах.	Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.	Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.	Өгсөн үүрэг даалгавар хэрэгжсэн байна.	Ажлын хариуцлага, сэхилгэ, дэт журмыг сайжруулах, ажил эрчимжүүлэх тухай НДЕГ-ын дэргтэн 01 тоот албан даалгаврын биелэлтийг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор гаргаж хүргүүлж байна. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хоёрдугаар сарын 15-ны дотор Хувийн Ашиг Сонирхлын Мэдүүлэг болон Хөрөнгө, Орлогын Мэдүүлэг (ХАСХОМ)-ээ шинэчлэн гаргаж тайлагнасан.	2025.01.01 2025.06.30	100%
4.2	Цаг үеийн шинж чанартай бусад үйл ажиллагаанд оролцох, хэрэгжилтийг хангах. /сумын ЗДТГ, төрийн байгууллагууд, НДГ, НДЕГ, аймгийн ЗДТГ-аас хамтарсан зохион байгуулагдах ажлууд/	Үйл ажиллагаанд оролцож хэрэгжилтийг бүр тухай бүр тайлагнаж ажигласан.	Нэмэлтээр өгсөн үүрэг даалгавар, зохион байгуулалтын ажлуудад идэвхтэй оролцоно.	Үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдах	НДЕГ-ын 2025 оны эхний хагас жилд зохион байгуулах долоо хоног бүрийн Баасан гарат тавигдаж буй нийгмийн даатгалын хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлал, зөвлөмжийн талаар мэдээллийн цагт цахимаар оролцдог.	2025.01.01 2025.06.30	100%

					2025 оны 03 сарын 09-ны өдөр Батхаан багт гарсан хээрийн түймэрт өртсөн айл өрхүүдийн эд хөрөнгийн хохирлын судалгааг гарган ажигласан. 2025 оны 4 сард сумын хэмжээнд зохион байгуулагдсан бүх нийтийн хог цэвэрлэгээнд ЗДТГ-ын алба хаагчидтай цуг гарч хог хаягдлын цэгийн ойр орчим болон сумын төвийн гудамж тайлбаг цэвэрлэсэн. Хөлөнбуйр сум байгуулагдсаны 80 жилийн ой болохтой холбоотой үндэсний сурын харваа зохион байгуулах ажлын хэсэгт орж төсөв, төлөвлөгөө, хийгдэх ажлын дараалал гарган ажиллаж байна. Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын нөхөн сонгууль 2025 оны 06 сарын 22-ны өдөр болох тул үйл ажиллагааг зохион байгуулах сумын сонгуулийн хөрөөнд орон ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	--

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮНЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Боловсрол, мэргэжил, мөргөшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлсэн ажиг	Эхлэх, дуусах огноо	Бие даан програмыг судлах
1	2	3	4	5	
1	Бие даан програмыг судлах	Фотошоп программ дээр ажиллаж сурсан байна.	Фотошоп програмыг компьютер дээрээ суулган зураг янзлах, Нийгмийн даатгалын үйлчилгээг сурталчилах гарын авлага, зурагт хуудсыг засварлан янзалж, Хөлөнбуйр сумын нийгмийн даатгал группд пост хийн ажиллаж байна.	2025.01.01 2025.06.30	100%

2	Монгол бичгийг бие даан судлах	Монгол бичгээр уншиж, компьютерт бичдэг болох	Хөлөнбуйр сумын хэлний зөвлөлөөс зохион байгуулсан монгол бичгийн үсгийн фонд ашиглах сургалтад хамрагдсан. Албан хэрэгцээнд монгол бичгийн үсгийн фондыг ажлын компьютертаа суулгаж, хэрэглэж байна. Би багш болзолт уралдаанд оролцогч С.Төмөрсүх багшийн зохион байгуулсан минутын уншлагын уралдаанд оролцсон.	2025.01.01 2025.06.30	100%
3	Удирдлагын академийн Төрийн албанаас зохион байгуулагдах төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдах	Мэргэшүүлэх сургалтад сурсан байна	Удирдлагын академийн Төрийн албанаас зохион байгуулагдах төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдах захиалга өгсөн боловч одоохондоо сургалт зарлагдаагүй байна.	2025.01.01 2025.06.30	-

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХӨЛӨНБУЙР СУМЫН БАЙЦААГЧ



А.ГАНЦЭЦЭГ

Огноо:

2025.06.10.